

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 59.020

Текстилийн тогтвортой үйлдвэрлэл – Удирдамж	MNS 6926:2021
Sustainable textile production – Code of practice	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн С/39 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулахад энэхүү стандартын зорилго оршино.

2. Хамрах болон хэрэглэх хүрээ

2.1 Энэхүү стандарт нь текстилийн үйлдвэрлэл эрхлэгчид болон тохирлын үнэлгээний байгууллагуудад тавих шаардлагыг тогтооход хамаарна.

2.2 Энэхүү стандартыг текстилийн тогтвортой үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгч болон түүнийг баталгаажуулах тохирлын үнэлгээний байгууллагууд хэрэглэнэ.

3. Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг ашигласан бөгөөд хэрэв эдгээр стандартад өөрчлөлт орвол хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

MNS ISO/IEC 17065:2013, Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага

MNS ISO/IEC 17067:2014, Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар,

MNS ISO/IEC 17021-1:2016, Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг ISO 19011:2016 Удирдлагын тогтолцоонд аудит явуулах заавар,

MNS ISO 14001:2016, Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, ашиглах арга зүйн заавар,

MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага,

MNS 6390:2013, Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага,

MNS 4288:1995, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага,

MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага,

MNS 6809:2019, Ямааны ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврөн нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн,

Захиалагч: AVSF XXX

Стандартын мэдээлэл лавлагаа сургалтын үндэсний төв 2021-08-23
Монгол Улсын стандарт мөн. Хувилан олшруулахыг хориглоно.

MNS 6926:2021

MNS 3683:2015, Текстиль. Ямааны хялгасыг ялгасан ноолуур. Техникийн шаардлага,
MNS 4950:2015, Текстиль. Тэмээний хялгасыг ялгасан ноос. Техникийн шаардлага,
MNS 5563:2005, Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага,
GLOBAL ORGANIC TEXTILE STANDARD (GOTS),
Step by OEKO TEX.

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1

текстилийн үйлдвэрлэгч

ширхэгт материал /ноос, ноолуур/-ыг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх бүхий л үйл ажиллагаандаа хуулийн өмнө хариуцлага хүлээх чадвартай этгээд,

4.2

текстилийн бүтээгдэхүүн

текстилийн бүх төрлийн түүхий эдийг боловсруулж үйлдвэрлэсэн эд, эдлэл,

4.3

текстилийн тогтвортой үйлдвэрлэл

зохистой дадал нэвтрүүлсэн бэлчээрийн мал аж ахуйгаас бэлтгэсэн түүхий эдийг байгальд ээлтэй технологиор боловсруулж нэмүү өртгийн сүлжээний хүрээнд үр өгөөж, үүрэг хариуцлагыг тэгш хуваарилах зарчмыг баримтлан ил тод, тасралтгүй, ёс зүйтэй үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаа,

4.4

байгальд ээлтэй технологи

хүрээлэн буй орчинд сөрөг ул мөр үлдээлгүй, байгалийн нөөц баялагийг хэмнэлттэй зарцуулах үйлдвэрлэлийн арга ажиллагаа,

4.5

текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо

текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаа, дүрэм, журмыг баримтлан тогтоосон шаардлага, шалгуур үзүүлэлтийг ханган хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа,

4.6

Нийгмийн хариуцлага

Үйлдвэрлэл эрхлэгчид нийт ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, цалин хөлсний болон удирдлагын харилцаанд хүний эрхийн түгээмэл тунхаглалд нийцүүлж хуулийн хүрээнд ажиллах цогц үйл ажиллагаа,

4.7

баталгаажуулалтын схем

нэг ижил тогтоосон шаардлага, дүрэм болон урам хэрэглэх тухайн бүтээгдэхүүнд хамааралтай баталгаажуулалтын тогтолцоо,

4.8

схем эзэмшигч

MNS ISO/IEC 17065:2013 стандартын хүрээнд төрийн захиргааны байгууллагаас итгэмжлэгдсэн ноос, ноолуурын салбарын мэргэшсэн баталгаажуулалтын байгууллага,

4.9

аудит

үйл ажиллагаа ба холбогдох үр дүн нь төлөвлөсөн зорилгод нийцэж байгаа эсэхийг тогтооход чиглэсэн, чиг үүргийн хувьд бие даасан, байнгын хяналт, үнэлгээ,

4.10

өөрийгөө үнэлэх

Тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог хэрэгжүүлэх анхны алхам бөгөөд өөрийн үйл ажиллагааг энэхүү стандартад заасан шалгуураар үнэлэн дутагдалтай талаа олж мэдсэнээр дахин сайжруулж уг дадлыг нэвтрүүлэхэд урьдчилсан байдлаар бэлтгэгдэх үйл ажиллагаа,

4.11

баталгаажуулалт

MNS ISO 17065:2013 стандартын хүрээнд төрийн захиргааны байгууллагаас итгэмжлэгдсэн ноос, ноолуурын салбарын баталгаажуулалтын байгууллагаас тогтвортой үйлдвэрлэлийн шаардлагад тохирч байгаа тухай баталгааг бичгээр гаргасан шийдвэр,

4.12

баталгаажуулалтын мэргэшсэн байгууллага

холбогдох хууль, журмын дагуу харьяалах төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, тухайн салбарт 20-иос дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, мэргэшсэн хүний нөөцтэй хуулийн этгээд,

4.13

баталгаажуулалтын шинжээч

ноос ноолуурын салбарын үйлдвэрлэлийн нарийн мэргэжлийн түвшинд 10-аас багагүй жил ажилласан туршлагатай, тогтвортой үйлдвэрлэлийн талаарх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан, тогтоосон шаардлага, стандартад тохирч буй эсэхэд үнэлгээ хийж буй хүн,

5 Тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 Үндсэн зарчим

5.1.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нийгэм, эдийн засаг, зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

5.1.2 Тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог нэвтрүүлэхэд өртгийн сүлжээнд оролцогч талууд харилцан итгэлцэл, үнэн зөв мэдээлэлд тулгуурлана.

5.1.3 Хэрэгжилтийн үе шат бүрд шинжээч болон баталгаажуулалтын байгууллагаар аудит хийлгэж, олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөнө.

5.1.4 Тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх зарчмыг баримтална.

5.2 Тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог хэрэгжүүлэх талуудын чиг үүрэг

5.2.1 Үйлдвэрлэгч байгууллагын чиг, үүрэг

5.2.1.1 “Монголын Хаан Ширхэгт” гэрчлэх тэмдэг бүхий бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж, монгол ноолуурын нэр хүндийг өсгөхөд бодит хувь нэмрээ оруулах

5.2.1.2 Тогтолцоог нэвтрүүлэх;

5.2.1.3 Боловсруулсан шалгуур, шаардлагын дагуу өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх;

5.2.1.4 Тогтолцоог хэрэгжүүлсэн талаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, баталгаажуулах хүсэлт гаргах

5.2.1.5 Хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах

5.2.1.6 Хэрэв үл тохирол гарвал түүнийг засаж залруулах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

5.2.1.7 Дахин сайжруулалтын тайлан гаргах, дахин үнэлүүлж, дүгнэлт гаргуулах

5.2.2 Баталгаажуулалтын байгууллагын чиг үүрэг

5.2.2.1 хүсэлт гаргагчийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ, аудит хийх

5.2.2.2 тогтвортой үйлдвэрлэгч тогтолцооны үйл ажиллагаанд үнэлгээ хийх

5.2.2.3 стандартын шаардлага бүрийг тогтоосон шалгуураар баталгаажуулах

5.2.2.4 үл тохирлыг залруулах, сайжруулах үйл ажиллагааны зөвлөмж өгөх

5.2.2.5 Баталгаажуулалтын шийдвэр гаргах, гэрчилгээ олгох

5.2.3 Сургалтын байгууллагын чиг үүрэг:

5.2.3.1 Текстилийн үйлдвэрүүдэд сургалт явуулах эрх бүхий байгууллага энэхүү стандартыг нэвтрүүлэх сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах;

5.2.3.2 Шинжээч, сургагч нарт сургалт явуулах, гэрчилгээ олгох;

5.3 Тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг

5.3.1 Дүрэм, журмууд

Баталгаажуулалтын байгууллага нь /схем эзэмшигч/ шаардлагатай бүх дүрэм, журмуудыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулж мөрдөж ажиллана.

Энэхүү дүрэм, журмуудад:

- Гарын авлага

- Аудитын дүрэм
- Баталгаажуулалтын журам
- Шийдвэр гаргах, гэрчилгээ олгох журам
- “Монголын Хаан Ширхэгт” гэрчлэх тэмдэг хэрэглэх журам
- Бусад дүрэм, журмуудыг хамруулсан байна.

5.3.2 Шалгуур үзүүлэлтийн хамрах хүрээ

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн үе шат бүрд тавих шаардлагын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоосон байна. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдэд:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл явц
- “Монголын Хаан Ширхэгт” гэрчлэх тэмдгийн хэрэгжилт
- Байгаль орчны менежментийн (цэвэр ус, бохир ус, эрчим хүч, химийн бодис, хог хаягдал, сав баглаа боодол) тогтолцоо
- Нийгмийн хариуцлагын менежментийн тогтолцоо (Хөдөлмөрийн харьцаа, цалин хөлс, эрүүл мэнд, хүчирхийлэл, гадуурхалт, хөдөлмөр хамгаалал) зэргийг хамруулна.

5.4 Баталгаажуулалт

5.4.1 Баталгаажуулалтын үндсэн зарчим:

- Баталгаажуулалт нь сонирхогч талуудад үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн үзүүлэлт, шаардлагад нийцэж буйн баталгаа
- Баталгаажуулалт нь үйлдвэрлэлийн явц тогтоосон шаардлагуудыг хангаж буйг гуравдагч тал буюу хараат бус хөндлөнгийн байгууллагаас мэргэжлийн түвшинд нотолж буй үнэн зөв, бодит байдлын үнэлгээ.

5.4.2 Баталгаажуулалтын үйл явц

5.4.2.1 Тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулах үйл ажиллагаа 6-р бүлэгт заасан шаардлагын дагуу хийгдэнэ.

5.4.2.2 Баталгаажуулалт нь түүнийг эзэмшигч этгээдийн үйл ажиллагаа нийгэм, эдийн засаг, зах зээлийн шаардлага (байгаль орчин, нийгмийн хариуцлага, мал амьтны эрх)-д нийцэж байгаа баталгааг сонирхогч бүх талуудад өгөхөд оршино.

6. Текстилийн тогтвортой үйлдвэрт тавих шаардлагууд

Текстилийн тогтвортой үйлдвэрлэлт тавих шаардлагуудыг хэрэгжүүлж ажиллана.

6.1 Байгаль орчин

- Байгаль орчны бодлоготой байна. Энэхүү бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ISO 14000 стандартаас загвар болгон ашиглаж болно.
- CO₂-ын ул мөрийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, байгаль орчны бодлогодоо тусгана.

6.1.1 Цэвэр ус

6.1.1.1 Нойтон боловсруулалтын дамжлага бүрт баталгаажуулсан усны тоолуур суурилуулна.

MNS 6926:2021

6.1.1.2 Нойтон боловсруулах дамжлага тус бүрт текстилийн нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэрэглээний бүртгэлийг тогтмол хөтөлнө (мЗ/кг).

6.1.1.3 Усны хэрэглээг багасгах жилийн төлөвлөгөөнд зорилтот тоон утгыг заана.

6.1.2 Бохир ус

6.1.2.1 Технологийн хаягдал усны гарц бүрт баталгаажуулсан усны тоолуур суурилуулна.

6.1.2.2 Үйлдвэрийн дамжлага бүрээс гарах технологийн хаягдал усны хэмжээг бүртгэнэ.

6.1.2.3 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус түүний чанар нь холбогдох “MNS 6390:2013 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.

6.1.2.4 Бохир ус цэвэрлэх байгууламж нь “MNS 4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага” стандартыг шаардлагыг хангасан байна.

6.1.2.5 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир усны чанарыг тогтмол хянаж, бүртгэл хөтөлнө.

6.1.2.6 Хаягдал усны гарцын хэмжээг багасгах, хоруу чанарыг бууруулах жилийн ажлын төлөвлөгөөнд зорилтот тоон утгыг зааж, үр дүнг үнэлж дүгнэнэ.

6.1.3 Эрчим хүч (цахилгаан, дулаан, уур)

6.1.3.1 Эрчим хүчний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ISO 14000, MNS ISO 50001:2019, Эрчим хүчний менежментийн тогтолцоо Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар стандартаас загвар болгон ашиглаж болно.

6.1.3.2 Үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт цахилгаан, дулааны энергийг хэмжих хэрэгсэл байрлуулна.

6.1.3.3 Нэгж бүтээгдэхүүн (1 кг) үйлдвэрлэлд зарцуулах эрчим хүчний зарцуулалтыг сар, улирал, жилээр бүртгэн мэдээллийн сан үүсгэсэн байна.

6.1.3.4 Агаарт хийн ялгарал үүсгэдэг бүх халаалтын дэд байгууламж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг тодорхойлж бүртгэл хөтөлнө.

6.1.3.5 Эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, хүлэмжийн хий, агаар бохирдуулагчийн ялгаралтыг бууруулах жилийн ажлын төлөвлөгөөнд зорилтот тоон утгыг заана.

6.1.4 Химийн бодис

6.1.4.1 Химийн бодисын импорт, дотоод худалдан авалт, хадгалалт, ашиглалт, тээвэрлэлт болон устгалын бүх үйл ажиллагааг хамарсан хууль, стандартад нийцсэн дотоод журамтай байна.

6.1.4.2 Химийн бодисын гарал үүсэл, шинж чанар, зориулалт, техникийн үзүүлэлт, ашиглалтын нөхцөлийг тодорхойлсон иж бүрэн мэдээллийн сан бий болгож бүртгэлжүүлсэн байна.

6.1.4.3 REACH, ZDHC, MRSL, RSL, Blue sign, GOTS, GreenScreen Certified, OEKO-TEX зэрэг Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй будаг болон химийн бодисуудыг сонгож хэрэглэнэ.

6.1.4.4 Ашиглаж буй химийн бодисын хольц найрлага, аюулын ангилал зэрэгт эрсдэлийн үнэлгээ хийж тэдгээрээс урьдчилан сэргийлэх, осол аюулын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

6.1.4.5 Нэхээсгүй үйлдвэрлэлд зөвхөн механик шахалт, торлох болон гидро барьцалдуулах аргууд ашиглана.

6.1.4.6 Бараа бүтээгдэхүүнтэй харьцаж буй машины эд ангийн тос, тосолгоо нь хүнд металл агуулаагүй байна.

6.1.4.7 MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан химийн бодисын агуулахтай байна.

6.1.4.8 Боловсруулах процесст химийн бодисын хаягдал хамгийн бага хэмжээнд хүргэх шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн байна.

6.1.4.9 Химийн бодис ашигласан технологийн процесст хүний оролцоо бага аюулгүй ажиллагаатай автоматжуулалтын систем нэвтрүүлсэн байна.

6.1.5 Үйлдвэрлэлийн хог хаягдал

6.1.5.1 Үйлдвэрлэлийн бүх шатанд түүхий эд, материалыг хэмнэх, хортой болон бусад бүх төрлийн хог хаягдлын гаралтыг бууруулах чиглэлээр дараах асуудлыг тусгасан журам, бүртгэлтэй байна.

6.1.5.2 Үйлдвэрлэлийн хаягдлыг үйлдвэрийн талбайд булах, хатуу ба шингэн хог хаягдлыг байгальд, гол мөрөнд хаяхыг хориглоно. (урьдчилан цэвэршүүлсэн хаягдал усанд хамаарахгүй)

6.1.5.3 Хатуу хог хаягдлыг шатаахыг хориглоно.

6.1.5.4 Бүтээгдэхүүний дахин ашиглалт, дахин боловсруулалтыг боломжийн хэмжээнд хүртэл ихэсгэнэ.

6.1.5.5 Хаягдлын хэмжээг бууруулах, гарсан хог хаягдлыг байгаль орчинд хор хөнөөлгүйгээр устгана.

MNS 6926:2021

6.1.5.6 Хог хаягдал, түүнийг зайлуулах, бүтээгдэхүүний орц нормын мэдээллийн сантай байна.

6.1.5.7 Хог хаягдлын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргыг хэрэглэх,

6.1.5.8 Хог хаягдлыг нэр төрөл, бодит хэмжээ, хортой, хоргүй, дахин ашиглах боломжтой, боломжгүй зэрэг үзүүлэлтээр ангилан ялгана.

6.1.6 Сав баглаа боодол

6.1.6.1 Дахин боловсруулж, гэрчилгээжүүлсэн цаас, картон, өлгүүр, сав баглаа боодол төрөл бүрийн шошгонуудад ашиглах төлөвлөгөөтэй байна.

6.1.6.2 Нийлэг, хуванцар сав баглаа боодлын ашиглалтыг багасгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

6.2 Нийгмийн хариуцлага

6.2.1 Хөдөлмөрийн харилцаа, сургалт

6.2.1.1 Ажил олгогч нь хууль эрх зүйн орчинд хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн гэрээг ажилтантай байгуулж тууштай мөрдөнө.

6.2.1.2 Ажилтан нь ажлын байранд томилогдохоос өмнө хөдөлмөрийн нөхцөл, ажлын хөлс, нийгмийн тэтгэмжийн талаар танилцаж, хөдөлмөрийн гэрээг байгуулна.

6.2.1.3 Ажилтнуудад эрүүл мэнд, аюулгүй байдлын сургалт тогтмол зохион байгуулж, бүртгэл хөтөлнө.

6.2.2 Насанд хүрээгүй хүний хөдөлмөр

6.2.2.1 Насанд хүрээгүй хүнийг хүйс хамаарахгүй ажиллуулахыг хориглоно.

6.2.3 Ялгаварлан гадуурхалт

6.2.3.1 Хүнийг арьс өнгө, каст, яс үндэс, харьяалал, шашин шүтлэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, жирэмслэлт, бэлгийн чиг баримжаа, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлийн байдал, улс төрийн үзэл бодол, намын гишүүнчлэл, нийгмийн гарал үүсэл болон ялгаварлал үүсгэх бусад бүх нөхцөлөөс шалтгаалан түүнд ялгавартайгаар хандан ажилд авах, нөхөн олговор олгох, сургалтад хамруулах, албан тушаал дэвшүүлэх, ажлаас халах, тэтгэвэрт гаргах, илүү цагаар ажиллуулах зэргийг хориглоно.

6.2.3.2 Түүнчлэн 8.2.8-д дурдсан ялгавартай байдлаас болж ажилтныг ажлын байранд дээрэлхэх, хүчирхийлэх, сахилгын арга хэмжээ авахыг хатуу хориглоно.

6.2.4 Доромжлол, хүчирхийллийн үл тэвчилт

6.2.4.1 Ажил олгогч нь ажлын байрыг доромжлол, хүчирхийллээс ангид байлгах үүрэг амлалт өгөх ёстой.

6.2.4.2 Хүйсээс үл хамааран бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, жендерт суурилсан хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.

6.2.4.3 Жендерт суурилсан бүх төрлийн хүчирхийллээс гарах үр дагаврууд тэр дундаа эмэгтэйчүүдэд нийгмийн болон хувийн амьдралд нь төрөл бүрийн хэлбэрээр учрах бие махбод, бэлгийн, сэтгэлзүйн дарамт, зовлон учруулахуйц үйлдэл, албадлага, эрх чөлөөнд нь халдах зэргийг хориглоно.

6.2.4.4 Бие махбодын хүчирхийлэл, сахилгын шийтгэл, бэлгийн дарамт хүчирхийлэл, сэтгэлзүйн дарамт, үгээр доромжлох, айлган сүрдүүлэх бүх төрлийн хэлбэрийг хориглоно.

6.2.4.5 Ажилтнуудын нэр төрд халдахгүй, хүндлэлтэй харьцана.

6.2.4.6 Хүний эрхийг хүндэлж хамгаална. Ажил олгогч хүний эрхийг хамгаалах тухай өөрийн үүрэг амлалтаа бодлогын баримт бичигт тусгах ёстой.

6.2.4.7 Доромжлол, хүчирхийлэл бусад дарамтын тухай нууцаар мэдэгдэх, тайлагнах боломжоор хангана. Ажлын байр бүрт гомдол санал хүлээж авах холбоо барих хаягийг ажилтан бүр хараад ойлгох боломжтой байдлаар байршуулна. Энэ мэдээллийг хөдөлмөрийн гэрээнд оруулж танилцуулна.

6.2.4.8 Сахилгын бүх арга хэмжээг бүртгэлжүүлнэ

6.2.4.9 Ажилтнууд нь эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх эрх чөлөөтэй байна.

6.2.5 Цалин хөлс

6.2.5.1 Дадлагажигч ажилтны цалин, тэтгэмжийг МУ-н хөдөлмөрийн хөлсний тогтоогдсон доод хэмжээнээс бууруулахгүй, мэргэшсэн ажиллагсдын цалинг салбарын жишиг дунджаас бууруулахгүйгээр тогтооно.

6.2.5.2 Цалин нь үндсэн хэрэгцээг хангахад хангалттай байна.

6.2.5.3 Үндэсний хууль тогтоомжийн дагуу ажлын цагтай байна.

6.2.5.4 МУ-ын хөдөлмөрийн хууль, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон хамтын хэлэлцээрт зааснаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар илүү цаг ажиллуулахыг шаардахгүй.

6.2.5.5 Ажилтнууд онц шаардлагатайгаас бусад жирийн үед долоо хоногт 40 цагаас илүүгүй ажилладаг байна.

6.2.5.6 Ажилтнууд завсарлага авч амрах эрхтэй байна. 1 цагийн цайны завсарлагатай байна. Дараалсан 2 ажлын өдрийн хоорондох тасралтгүй амралтын цаг 12 цагаас доошгүй байна.

MNS 6926:2021

6.2.5.7 Илүү цагийн нөхөн олговрыг МУ-н хөдөлмөрийн хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

6.2.5.8 Сахилгын арга хэмжээгээр цалингаас суутгал хийхийг хориглоно.

6.2.6 Эрүүл мэнд хөдөлмөр хамгаалал

6.2.6.1 Ажлын байр нь цэвэр, аюулгүй, ажилчдын үндсэн хэрэгцээг хангана.

6.2.6.2 Цэвэр ариун цэврийн өрөө, MNS 0900 : 2018, “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартын шаардлага хангасан ундны усаар хангана. Шаардлагатай тохиолдолд ажилчдын амрах өрөө, хоолны газар, хоол хүнс хадгалах газруудтай байна. Эдгээр нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

6.2.6.3 Аюулаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зохих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж баримтжуулна.

6.2.6.4 Ажил мэргэжлийн онцлогтой холбоотой аваар осол гарах үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байна.

6.2.7 Мал амьтны эрх

6.2.7.1 MNS 6891:2020, “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага” стандартын дагуу мал амьтны тавлаг байдлыг хангасан, гарал үүсэл нь тодорхой, тохирлын гэрчилгээтэй ноос ноолууран түүхий эдийг хүлээн авна.

ТӨГСӨВ.